

**“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

ХУРЛЫН ТОВ

Огноо: 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

Цаг: 11:00-14:00

Хурал болсон газар: 17 давхар, Сентрал Тауэр, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Улаанбаатар хот.

ХУРЛЫН ИРЦ

Хурлын дарга: Ч. Ганхуяг /ТУЗ-ийн дарга/

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын тоо: 30

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын саналын эрхтэй хувьцааны тоо: 12,231,149

Хурлын ирц: 61.21%

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. 2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. 2025 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
4. 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах (саналын хуудас);
5. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
6. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлах (саналын хуудас);
7. ТУЗ-ийн 2026 оны зардлын төсөв батлах тухай (саналын хуудас).

Хурлын дарга Ч.Ганхуяг:

Хурлыг нээж, хурлын дэг болон хэлэлцэх асуудлыг танилцуулж баталснаар хурлыг эхлүүлээ. Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн даргын хувьд Нэгдэлийн хурлыг удирдлагын багийн гишүүд болон захирлуудыг урин танилцуулав.

Дүрэмд өөрчлөлт оруулж байгаатай холбоотойгоор захирлуудыг танилцуулахыг хүслээ. Ард санхүүгийн Нэгдэл ХК-аас зарим компаниуд салж Ард инвестмэнт групп ХК доор нэгдсэн байгаа.

Ард санхүүгийн Нэгдэл ХК-д нэг том өөрчлөлт орсон нь компанийн Гүйцэтгэх захирал байсан Б.Золбоо ажлаа өгснөөр удирдлагын багт өөрчлөлт оруулах шаардлагатай талаар хурлын үеэр илүү дэлгэрэнгүй ярилцана гэв.

Захирлууд тус бүр товчхон өөрсдийн албан тушаалын танилцуулгыг хийв.

Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл:

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 26/1 тоот тогтоол: Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн саналын эрхтэй нийт 19,982,392 ширхэг энгийн хувьцаанаас 12,231,149 ширхэг буюу 61.21 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байна. Иймд ирц хүрсэн, хурал хүчин төгөлдөр болж байна.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 1: Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах тухай - Хурлын дарга болон Гүйцэтгэх удирдлагын баг

2025 онд группийн хэмжээнд нийт 15 компани үйл ажиллагаа явуулж байна. Нийт 268 ажилтантай. Давхардсан тоогоор 115,049 хувьцаа эзэмшигчтэй болжээ. Ард Апп хэрэглэгч – 1,125,930, АрдКидс хэрэглэгч – 60,685, АрдКойн эзэмшигч – 248,543, идэвхтэй зээлийн дансны тоо – 32,746, даатгуулагчдын тоо – 180,041, тэтгэврийн хуримтлал эзэмшигч – 130,410, үнэт цаасны данс эзэмшигч – 167,259, Ард Актив ХЗХ-ны гишүүд – 6,740. Нийт нэгдлийн хэмжээнд 20 тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байна.

Ард Санхүүгийн Нэгдэл нь банкны, даатгалын болон хөрөнгө оруулалтын банкны нэгтгэлийн доор компаниудаа хуваарилан үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байна. Манай экосистем нь технологи, дэд бүтэц болон уламжлалт санхүүгийн цогц уялдаа дээр суурилдаг. Бидний гол борлуулалт, үйлчилгээний суваг бол Ард Апп юм. Сүүлийн 6 сарын хугацаанд аппын үйл ажиллагаа мэдэгдэхүйц сайжирсан. Энэхүү тогтолцоо нь дахин давтагдашгүй, дахин угсрах боломжгүй дэд бүтэц дээр тулгуурласан гэдгээрээ бид бахархдаг.

Нэгдэлийн онцлох үйл явдлыг танилцуулахаар Үйл ажиллагаа хариуцсан захирал бөгөөд Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Уянга танилцуулав.

- Ард Аппын хөгжүүлэлт улам чанаржиж, V хувилбараа шинэ өнгө дизайнтайгаар танилцуулсан нь харилцагчдын талархлыг хүртэв.
- Түүхийн шинэ хуудас! Бид хөгжил дэвшлийнхээ дараагийн хуудсыг нээснээ илэрхийлэн шинэ өнгө төрхөө танилцуулав.
- Монгол Улсын хувьд анх удаа хувьцаа халааслах болон хувьцаа солих ажлыг нэг дор хийж, Хөвсгөл ХК-ийн хувьцаагаар солих боломжийг хувьцаа эзэмшигчдэдээ олгов.

- Хөрөнгө Оруулагч Үндэстэн 2025 Чуулганаа 10 дахь жилдээ өөрсдийн бүтээн байгуулалт болох ОРИ Студиост амжилттай зохион байгуулав.
- Лондонд төвтэй Абрахам Хаустай хамтран санхүүгийн бүх үйлчилгээг нэг дор цогцлоосон Ард Аппын технологийн шийдлийг иргэдийн санхүүгийн хэрэгцээнд нэвтрүүлэхээр болов.
- AIGroup Австрид төвтэй Teichmann & Compagnons Property Networks GmbH компанитай хамтран Монгол Улсад Ухаалаг Хот хөгжүүлэх стратегийн хамтын ажиллагааг эхлүүлэв.
- AIGroup & ChainUp Pte.LTD Монгол Улсын дижитал эдийн засгийг хөгжүүлэх, санхүүгийн инновацын аюулгүй, зохицуулалттай орчныг төлөвшүүлэх зорилтын хүрээнд хамтран ажиллахаар болов.
- ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг Дэлхийн Эдийн Засгийн Форумын Шинэ Аваргуудын Зөвлөх Хороонд томилогдон ажиллахаар болов.
- Ард Санхүүгийн Нэгдэл Медиа, технологи, блокчэйн, крипто салбарт үйл ажиллагаа үзүүлэгч компаниудаа Хөвсгөл компанийн бүтцэд нэгтгэн AIGroup хэмээн нэрийдэх болов.

Банкны нэгтгэлийн онцлох үйл явдал болон гүйцэтгэлийг Нэгтгэлийн ахлагч бөгөөд Ард Кредит ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар танилцуулав.

- Ард Кредит: “Банкирс Крауд Кредит”-тэй хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурж, 5 сая долларын санхүүжилтийн хэлцлийг амжилттай байгуулав.
- Ард Кредит: ISO 27001:2022 “The Information Security” 3 дахь жилийн аудитын шалгалтыг амжилттай дуусгаж, гэрчилгээ хүлээн авлаа.
- Ард Кредит: Харилцагчийн боловсрол цэсийг вебсайтад хөгжүүлж, санал хүсэлт авах ажлыг эхлүүлэв. Олон нийтийн танигдалт брэнддинг судалгааг хийв.
- Ард Кредит: Lendable компанитай анхны уулзалтаа амжилттай хийж, NDA гэрээг байгууллаа.
- Ард Кредит: IDCXS:2022 International Digital Customer Experience Standard-ыг амжилттай нэвтрүүлэв.
- Ард Актив: Гишүүддээ зориулсан сургалтуудыг жилийн турш тогтмол зохион байгуулав.
- Ард Кредит: Surfin компани NDA болон хамтын ажиллагааны гэрээг байгууллаа.
- Ард Кредит х Монгол Шуудан хамтран ухаалаг ПОС системээр дамжуулан санхүүгийн үйлчилгээг 21 аймаг, 330 сумыг хамарсан бүрэн сүлжээ бүрдүүлэв.
- Ард Актив: Хөрөнгө оруулагч үндэстэн чуулганд 10 дахь жилдээ амжилттай оролцов.

Ард Апп -

- Ард Кредит: BIPV барилгын фасад, дээвэр, шилэнд нэгтгэгдсэн нарны эрчим хүч үйлдвэрлэх Ногоон зээлийн хүсэлтийг Ард Аппаар дамжуулан авч байна.

- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн FICO кредит онооны системийг нэвтрүүлж, хос онооны системийг бүрдүүлэв.
- Ulaanbaatar coffee болон Magic store vending машинуудад холбогдон, хамтран идэвхжүүлэв.
- Ард Кредит: ArdPay брэндинг шинэчлэж, баярын урамшуулалт хөтөлбөрийг хамтран идэвхжүүлж, Ардын мерчант хөнгөлтийг нэмэгдүүлж ажиллав.
- Зогсоолын төлбөрийг Ард Аппаас төлөх боломжтой болов.
- Хэрэглэгчид Виртуал хөрөнгийг Ард Аппаар шууд худалдан авах боломжтой боллоо.
- UBEats аппликейшнтэй уялдуулснаар хэрэглэгчид Ард Апп ашиглан хоол захиалж, шууд төлбөр хийх боломжтой боллоо.
- Монгол сим, Ори багц, Tapatrip мини аппад нэвтэрч, хамтран идэвхжүүлэв.

АрдКидс – 2024–2025 онд бүртгэлтэй хэрэглэгчдийн тоо 8%-аар өсөж, хүүхдийн хадгаламж 36.8%-аар, нийт гүйлгээний дүн 78.2%-аар нэмэгдсэн. Хүүхдийн баярыг тохиолдуулан гар зургийн болон зохион бичлэгийн уралдаан зохион байгуулж, нийт 1,200 гаруй хүүхэд оролцсоноос 68 хүүхдийг шалгаруулан шагнаж урамшууллаа.

Интернэт банк -

- Төлбөр тооцоо: QR гүйлгээ - Бүх банкнаас төлбөр хүлээн авах боломжтой
- АрдКойн урамшуулал: Бүх мерчантад төлбөр төлөхдөө 10% ардкойноор төлөх боломж
- Хуваан төлөх үйлчилгээ: ₮5,000,000 хүртэл дүнгээр хүүгүй, шимтгэлгүй 2-6 удаа хүртэл хуваан төлөх боломж
- АрдКойн урамшуулал: Үнийн дүнгийн 1%-д харилцагчаа урамшуулах 10,000 ардкойныг бүх мерчантад бэлэглэв.

Банкны нэгдлийн гүйцэтгэл тогтвортой өсөлттэй байна. Нийт хөрөнгө ₮185.3 тэрбумд хүрч, зээлийн багц ₮119.6 тэрбум, санхүүжилт ₮118.6 тэрбум болсон. Тайлант хугацаанд ₮5.4 тэрбумын цэвэр ашигтай ажиллаж, ашигт ажиллагаа 13.1%-д хүрсэн.

Нийт зээлийн олголт ₮186.4 тэрбумд хүрч, 142,997 зээл олгосон нь үйл ажиллагааны идэвх өндөр байгааг харуулж байна. Зээлийн бүтцэт онлайн зээл давамгайлж, харилцагчдын 57% нь эмэгтэй, 43% нь эрэгтэй байна. Салбарын дундажтай харьцуулахад чанарын үзүүлэлтүүд (ЖДХҮ, ХҮТЧ) тогтвортой түвшинд хадгалагдаж байна.

Даатгалын нэгтгэлийн онцлох үйл явдал болон гүйцэтгэлийг Нэгтгэлийн ахлагч бөгөөд Ард Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Эрдэнэтулга танилцуулав.

- Ард Даатгал: ISO 9001, ISO 27001 нэгдсэн менежментийн стандартыг амжилттай нэвтрүүллээ.
- Ард Даатгал: Баталгааны даатгалын үйлчилгээг нэвтрүүлэн 276 гэрээ хийж, 27 тэрбум төгрөгийн баталгаа гаргалаа.

- Ард Даатгал: Монголын волейболын Үндэсний дээд лигийн “Хасу Мегастарс” багтай хамтын ажиллагаагаа хоёр дахь жилдээ амжилттай үргэлжлүүлээ.
- Ард Даатгал: Тээврийн хэрэгслийн даатгалын сунгалтыг мессежээр хийж эхэллээ.
- Ард Даатгал: Ногоон зээлийн хүрээнд ногоон даатгалын бүтээгдэхүүн нэвтрүүлж хамтран ажиллаж байна.
- Ардын Тэтгэврийн Данс: “Хувийн тэтгэврийн сан гэж юу вэ?” нээлттэй танилцуулгыг тогтмол зохион байгууллаа.
- Ард Даатгал: Даатгуулагч нарт хураамжийн 5 хувьтай тэнцэх ардкойныг урамшуулал болгон олголоо.
- Ард Даатгал: Сингапурын олон улсын давхар даатгалын зөвлөгөөн (SIRC)-д амжилттай оролцож, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлээ.
- Ардын Тэтгэврийн Данс: Ардын Альфа урамшуулал 2025: Байртай - Хадгаламжтай - Бэлэгтэй урамшуулалт хөтөлбөр зарлаллаа.

Даатгалын нэгтгэлийн гүйцэтгэлийн хувьд Нийт хөрөнгө ₮125.6 тэрбумд хүрч, цэвэр ашиг ₮1.2 тэрбум, нийт орлого ₮50.9 тэрбум байна. Нийт даатгуулагчийн тоо 131,280 бөгөөд үүнээс 19% байгууллага, 81% нь хувь хүн байна.

Хөрөнгө оруулалтын банкны нэгтгэлийн онцлох үйл явдал болон гүйцэтгэлийг Нэгтгэлийн ахлагч бөгөөд Ард Секюритизийн Гүйцэтгэх захирал Х.Билгүүн танилцуулав.

- Ард Секюритиз: Кроонос компанийн бондын андеррайтераар амжилттай ажиллан борлуулав.
- Ард Секюритиз: ӨндөрХаан ХК-ийн өрийг хувьцаагаар солих зөвшөөрлийг авах хүсэлт өгөв.
- Ард Приорити: Ард Санхүүгийн Нэгдэл дор хувийн банк болох Ард Приорити компани үүсгэн байгуулагдав.
- Ард Секюритиз: Ард Инвестмент Групп ХК-ийн хувьцаагаар солих замаар Ард Санхүүгийн Нэгдлийн хувьцааг халааслах ажлыг амжилттай гүйцэтгэв.
- Ард Секюритиз: Ард Кредит, Ард Даатгал, МОСТ Финтек ХК-уудын хувьцааг idax бирж дээр токенжуулах танилцуулгыг хийж гүйцэтгэв.
- Ард Лизинг: Хөрөнгө оруулалтын багцаа төрөлжүүлэн 5 саяын багцтай болов.
- Ард Секюритиз: Атмор компанийн бондын андеррайтераар амжилттай ажиллан борлуулав.
- Ард Менежмент: 2025 оны эцэст Үндэсний Хувьчлалын сангийн нэгж эрхийн үнэ цэнэ (NAV) 151.16 төгрөг болж, 2022 оны 4-р сараас хойшхи хамгийн өндөр түвшинд хүрэв.
- Ард Лизинг: Ардын баг улс орон даяар аялал зохион байгуулж, хэрэглэгч төвтэй үйлчилгээ хүргэхээр Монгол орны өнцөг булан бүрт хүрч ажиллав.

Хөрөнгө оруулалтын банкны нэгтгэлийн гүйцэтгэлийн хувьд Нийт хөрөнгө ₮130.0 тэрбум, эздийн өмч ₮13.3 тэрбум, санхүүжилт зуучлал ₮114.3 тэрбум байна. Нийт удирдаж буй хөрөнгө ₮20.6 тэрбум байгаа бол нийт арилжаа ₮39.8 тэрбум.

Ардкойнын тоон үзүүлэлт, тархалтын мэдээлэл, компаниудын жагсаалт, мерчант болон олголт, буцаан худалдан авалт, 2026 оны төлөвлөгөөний мэдээллийг Ард Бит ХХК-ийн Гүйцэтгэх захирал О.Мөнх-Оргил танилцуулав.

Тоон үзүүлэлт

- ₮34.7 тэрбум 2025 оны нийт арилжаа
- 42.96% 2025 оны дотоодын арилжаанд эзлэх хувь
- ₮225 тэрбум, Зах зээлийн үнэлгээ
- +264 мянган, Токен эзэмшигч
- +1,000, Мерчант байгууллага

Түмэн Ард - Түмэн боломжийн товч мэдээллийг Ард Ухаалаг Үндэстэн, Гүйцэтгэх захирал бөгөөд Түмэн ардын удирдагч О.Заяа танилцуулав.

Түмэн Ардын Брокерын жилийн өсөлт 114%, Ардын Ноён 54%, Ардын Элч +113%, Ардын Альфа +100% өсөлттэй байна. Түмэн Ардын нийт гишүүдийн тоо 101%-иар өссөнөөр борлуулалт +332%-ийн өсөлттэй гарсан байна.

Түүнчлэн, 2025 онд Түмэн Ард нийт 388.6 сая төгрөгийн үнэ бүхий Ардкойныг гишүүдэд борлуулалтын урамшууллын хэлбэрээр тараасан байна.

Мэдээллийн технологи, дижитал шилжилтийн ахиц, үр дүнгийн тухай АСН ХК-ийн Дижитал шилжилт хариуцсан захирал бөгөөд Ард Финтек солюшн ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Баттулга танилцуулав.

Байгууллагын дотоод технологийн дэд бүтцийг бий болгов.

- Мобиком дата төвд сервер тоног төхөөрөмжийг суурьлуулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэв
- Blue sky office, Mobicom дата төвийн хооронд шилэн кабелийн шөрмөсийн холболт гүйцэтгэж шууд холболт бий болгов
- IPS, Firewall, L3 Management Switch ийг суулгаж тохируулан үйл ажиллагаанд нэвтрүүлэв.

WINDOWS ACTIVE DIRECTORY-г үйл ажиллагаанд нэвтрүүлэв

- Ард Кредит ББСБ ХК-ийн ажилтнуудын компьютерт Windows 11 үйлдлийн системийг суулгаж тохируулав
- Домайн хэрэглэгчийг үүсгэж, антивирус программ хангамжийн автомат хуваарь тохируулав.

ERP систем үйл ажиллагаанд нэвтрүүлэв

- Цаг бүртгэл, Хүний нөөцийн модулийг үйл ажиллагаанд нэвтрүүлэв
- Ардын 15 вэбсайтыг өөрсдийн орчинд нэгтгэж бэлэн байдлыг хангав
- Сугалааны програм хөгжүүлж, үйл ажиллагаанд нэвтрүүлэв

Gitlab code management, version control system нэвтрүүлэв. Дотоод хөгжүүлэлтийн төвлөрсөн удирдлага, хөгжүүлэлтийн процесс, кодын удирдлагын ил тод байдлыг бий болгов.

Нууцлал аюулгүй байдлыг нэмэгдүүлэв

- Cloudflare web application security сервис нэвтрүүлэв
- Grafana monitor dashboard үйл ажиллагаанд нэвтрүүлэв
- PAM Jump server privileged access систем нэвтрүүлэв
- Microsoft Defender endpoint Plan 2 антивирус программ нэвтрүүлж, төвлөрсөн удирдлага, хяналтыг бий болгов.

АСН ХК-ийн Санхүү хариуцсан захирал бөгөөд Ард Актив ХЗХ-н Гүйцэтгэх захирал Г.Билгүүн нь Тусдаа орлого, үр дүнгийн тайлан, тусдаа санхүүгийн тайланг дэлгэрэнгүй танилцуулсны зэрэгцээ компанийн топ 15 хувьцаа эзэмшигчийн бүтэц болон хувьцааны арилжааны талаар Х.Билгүүн танилцуулга хийлээ.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 2: 2025 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах тухай – Нексиа Глобал Монголиа Аудит ХХК

Өөрсдийн аудитын компанийн талаар товч танилцуулж, Ард Санхүүгийн Нэгдэлтэй 2025 оны жилийн тайлангийн хүрээнд хамтран ажилласан талаар мэдээлэв. Аудитын дүгнэлт, үнэлгээг хувьцаа эзэмшигчдийн хурлын материалд тодорхой тусгасныг тайлбарлан танилцууллаа.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 3: 2025 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай – ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг танилцуулав.

ТУЗ-ийн ээлжит болон ээлжит бус хурал 6 удаа, хороодын хурал 9 удаа болж, эчнээ санал хураалтыг 13 удаа явуулж, нийт 32 асуудал шийдвэрлэгджээ. Эдгээрээс онцлох шийдвэр, чухал асуудлыг танилцуулж, мөн ТУЗ-ийн хурлын тус бүрийн ирцийг танилцууллаа.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 4: 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай - Хурлын дарга Ч.Ганхуяг санал хураалтын “Саналын хуудас”-ыг танилцуулж, дүгнэлтийг танилцууллаа.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийг Компанийн тухай хууль, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн дүрмийн холбогдох заалтын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна.

Ард Санхүүгийн Нэгдэл өнгөрсөн 5 жилийн хугацаанд цахим шилжилт, үүнээс сүүлийн 2 жилд нь компанийнхаа бүтцийн өөрчлөлтийг хийж, засаглал, менежментийн бодлогоо шинэчилж, дотоод технологийн хувьд төгөлдөршүүлэн ирээдүйн өсөлтийн дэд бүтцээ үндсэндээ угсарч дуусгалаа.

2025 оны онцлох үйл явдлыг товчхон дурдвал:

- Компанийн түүхэнд тэмдэглэгдэн үлдэх нэгэн томоохон үйл явдал бол хэмээх нэрийтгэл бүхий гал улаан өнгийг бэлгэдэл болгон ашиглаж ирсэн логогоо зоримог шийдвэр гарган, хөгжил дэвшлийнхээ дараагийн хуудсыг нээснээ илэрхийлэн, олон улсын тэлэлт, компанийн хөгжил дэвшлийн шинэ үе шат руу шилжиж буй үйл явцыг онцлон шингээсэн өнгө төрх бүхий бэлгэдэл тэмдгээр солилоо.

- Монгол Улсын хувьд анх удаа хувьцаа халааслах болон хувьцааг хувьцаагаар солих ажлыг нэг дор хийж, нийт хувьцааны 16 орчим хувийг зах зээлээс эргүүлэн халаасалж, Хөвсгөл ХК-ийн хувьцаагаар солих боломжийг хувьцаа эзэмшигчдэдээ олгосон.

- Ард Апшын технологийн шийдлийг олон улсад иргэдийн санхүүгийн хэрэгцээнд нэвтрүүлэх болсноор Лондонд төвтэй Дэлхийн өнцөг булан бүрт санхүүгийн мэдлэг, хүртээмжийг нэмэгдүүлэх үйлсийг дэмжин ажилладаг Абрахам Хаустай хамтран санхүүгийн бүх үйлчилгээг нэг дор цогцлоосон аппликэйшны хэрэглээг тэлэх ажлыг албажуулан хамтын ажиллагааны санамж бичиг үзэглэв

- Олон улсын Surfin AI компанитай стратегийн хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, хиймэл оюуны эринд нэгмөр шилжих түүхэн санаачилгыг эхлүүлсэн явдал боллоо.

Нексия Глобал Монголиа Аудит ХХК хөндлөнгийн аудитаар сонгогдон ажилласан ба компанийн санхүүгийн тайланд эерэг үнэлгээ өгсөн бөгөөд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс Ард Санхүүгийн Нэгдэл ХК 2025 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн ашиглаж ажилласан гэж үзэн Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг "Хангалттай" гэж дүгнэлээ.

Өөр санал хүсэлт байхгүй гэснээр дараагийн хэлэлцэх асуудалд орлоо.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 5: Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай - ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг танилцуулав.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 2 сарын 19-ний өдрийн 26/03 тоот тогтоолоор 2025 оны санхүүгийн жилд хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэв.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 6: Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай - ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг танилцуулав.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн тухайд

Нэгдүгээрт, 1.3 Компани нь “Хүчтэй. Хамтдаа.” гэсэн уриа үгтэй байх бөгөөд компанийн бэлгэдэл тэмдэг нь “Ард” гэсэн гурван үсгээс бүрдсэн улаан өнгөтэй байх ба хажууд нь санхүүгийн нэгдэл гэж бичсэн байна гэснийг “1.3 Компани нь Хүчтэй. Хамтдаа. гэсэн уриа үгтэй байх бөгөөд бэлгэдэл тэмдэгтэй байна” гэж өөрчлөв.

Хоёрдугаарт, 1.5 Компанийн албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байр, хоёр давхарт; гэснийг “1.5 Компанийн албан ёсны хаяг: “Монгол улс, Улаанбаатар Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Соёл амралтын хүрээлэн /14240/, энхтайваны өргөн чөлөө гудамж 17 дугаартай барилгын 9 дүгээр давхарт.” гэж өөрчлөв.

Гуравдугаарт, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.2-т зааснаар “Компанийн дүрэмд гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлэхээр заагаагүй бол хувь хүн хэрэгжүүлнэ” гэх заалтыг үндэслэн Гүйцэтгэх удирдлагыг хувь хүн буюу Гүйцэтгэх захирлаар хэрэгжүүлэхээр заасанд багийн хэлбэрээр хэрэгжүүлэх зохицуулалтыг нэмж, түүнд шаардлагатай бусад өөрчлөлтүүдийг оруулав.

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН ДҮРМИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

(хураангуй төсөл)

ОДООГИЙН ЗААЛТ (2024/4/27 батлав)	НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ (2026/4/30 батлав)
НЭГ. Нийтлэг үндэслэл	НЭГ. Нийтлэг үндэслэл
1.3 Компани нь “Хүчтэй. Хамтдаа.” гэсэн уриа үгтэй байх бөгөөд компанийн бэлгэдэл тэмдэг нь  гэсэн гурван үсгээс бүрдсэн улаан өнгөтэй байх ба хажууд нь санхүүгийн нэгдэл гэж бичсэн байна.	“1.3 Компани нь “Хүчтэй. Хамтдаа.” гэсэн уриа үгтэй байх бөгөөд <i>бэлгэдэл тэмдэгтэй байна.</i> ”
1.6 Компанийн албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн байр, хоёр давхарт;	“1.6 Компанийн албан ёсны хаяг: “Монгол улс, Улаанбаатар Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Соёл амралтын хүрээлэн /14240/, энхтайваны өргөн чөлөө гудамж 17 дугаартай барилгын 9 дүгээр давхарт.”
ГУРАВ. Компанийн үндсэн эрх, үүрэг	ГУРАВ. Компанийн үндсэн эрх, үүрэг
3.4 Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл болох санхүү, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь ТУЗ-ийн удирдлага, хяналтын дор явагдах бөгөөд Гүйцэтгэх	“3.4 Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл болох санхүү, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь ТУЗ-ийн удирдлага, хяналтын дор явагдах бөгөөд гүйцэтгэх

захирал нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааны шийдвэр болон компанийн нэгдлийн эрх ашигт нийцсэн, нэгдлийн үйл ажиллагаанд чухал, зайлшгүй шаардлагатай асуудлаар нэгдлийн оролцогч компаниудын гүйцэтгэх удирдлагад чиг үүрэг өгөх, түүний хэрэгжилтийг хангуулж ажиллах эрхтэй байна.	захирал эсхүл <i>гүйцэтгэх удирдлагын баг</i> нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааны шийдвэр болон компанийн нэгдлийн эрх ашигт нийцсэн, нэгдлийн үйл ажиллагаанд чухал, зайлшгүй шаардлагатай асуудлаар нэгдлийн оролцогч компаниудын гүйцэтгэх удирдлагад чиг үүрэг өгөх, түүний хэрэгжилтийг хангуулж ажиллах эрхтэй байна.”
ДӨРӨВ. Компанийн үндсэн хариуцлага	ДӨРӨВ. Компанийн үндсэн хариуцлага
4.3 Компанийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, Санхүү хариуцсан захирал, Ерөнхий нягтлан бодогч нар нь гэрээнд заагдсан хугацаанд эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд өөрийн хууль бус үйл ажиллагаанаас шалтгаалж компанид учруулсан хохирлыг хариуцна.	4.3 Компанийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал эсхүл <i>Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд</i> , Санхүү хариуцсан захирал, Ерөнхий нягтлан бодогч нар нь гэрээнд заагдсан хугацаанд эрх бүхий албан тушаалтан байх бөгөөд өөрийн хууль бус үйл ажиллагаанаас шалтгаалж компанид учруулсан хохирлыг хариуцна.
НАЙМ. Төлөөлөн Удирдах Зөвлөл, түүний бүрэн эрх	НАЙМ. Төлөөлөн Удирдах Зөвлөл, түүний бүрэн эрх
8.7 ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, компанийн гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад этгээдийн шаардлага, санаачилгаар хуралдуулна. ТУЗ эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.	8.7 ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, компанийн Гүйцэтгэх захирал эсхүл <i>“гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд”</i> болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад этгээдийн шаардлага, санаачилгаар хуралдуулна. ТУЗ эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.
ЕС. Гүйцэтгэх Удирдлага	ЕС. Гүйцэтгэх Удирдлага
9.1 Компанийн гүйцэтгэх удирдлага (цаашид “Гүйцэтгэх захирал” гэх) нь энэ дүрэмд заасан болон ТУЗ-тай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.	9.1 Компанийн <i>гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал эсхүл багаар хэрэгжүүлэх</i> бөгөөд энэ дүрэмд заасан болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

9.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрсөн тохиолдолд гүйцэтгэх захирал өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад давхар ажиллаж болно.	9.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн зөвшөөрсөн тохиолдолд <i>Гүйцэтгэх захирал эсхүл гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд</i> өөр компани, аж ахуйн нэгжийн удирдлагад давхар ажиллаж болно.
9.3 Гүйцэтгэх захирал нь Зохицуулалттай хуулийн этгээдээс бусад хараат болон охин компанийн Гүйцэтгэх захирлыг нэр дэвшүүлэх, санал болгох эрхтэй.	9.3 Гүйцэтгэх захирал эсхүл <i>Гүйцэтгэх удирдлагын баг</i> нь Зохицуулалттай хуулийн этгээдээс бусад хараат болон охин компанийн Гүйцэтгэх захирлыг нэр дэвшүүлэх, санал болгох эрхтэй.
9.7 Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болно.	9.7 Компанийн Гүйцэтгэх захирал эсхүл <i>гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд</i> нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байж болно.
9.8 Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх, гэрээ байгуулах зэрэг Компанийн тухай хууль болон энэ дүрэмд зааснаар компанийг бүхий л харилцаанд итгэмжлэлгүйгээр төлөөлнө.	9.8 Гүйцэтгэх захирал эсхүл <i>Гүйцэтгэх удирдлагын баг</i> нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.
9.9 Гүйцэтгэх захирал нь албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-д нэг сарын өмнө бичгээр мэдэгдсэнээр ТУЗ-ийн хурлаар авч хянан хэлэлцэнэ.	9.9 Гүйцэтгэх захирал эсхүл <i>Гүйцэтгэх удирдлагын багийн ахлагч болон гишүүд</i> нь албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-д нэг сарын өмнө бичгээр мэдэгдсэнээр ТУЗ-ийн хурлаар авч хянан хэлэлцэнэ.
9.10 ТУЗ Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг зогсоох, хязгаарлах эрхийг хэзээ ч хязгаарлаж болно.	9.10 ТУЗ Гүйцэтгэх захирлын эсхүл <i>Гүйцэтгэх удирдлагын багийн бүрэн эрхийг</i> зогсоох, хязгаарлах эрхийг хэзээ ч хязгаарлаж болно.
9.11 Гүйцэтгэх захирлын жил бүрийн гүйцэтгэлийн үнэлгээг холбогдох хороогоор хэлэлцэж, ТУЗ-д тухай бүр тайлагнаж ажиллана.	9.11 <i>Гүйцэтгэх удирдлага</i> жил бүрийн гүйцэтгэлийн үнэлгээг холбогдох хороогоор хэлэлцэж, ТУЗ-д тухай бүр тайлагнаж ажиллана.

ТУЗ-ийн дарга тус өөрчлөлтийн танилцуулгыг хийснээр Компанийн засаглалын бүтэц, өөрчлөлтийг танилцуулж, Удирдлагын багаар Захирлуудын зөвлөлийн багийг ажиллууллахаар танилцуулж, доорх этгээдийг захирлуудын зөвлөлийн гишүүдээр танилцуулав. Үүнд:

1. Ерөнхий захирал - Г.Уянга (багийн ахлагч)
2. Банкны нэгтгэлийн ахлагч - Г.Сүхбаатар
3. Хөрөнгө оруулалтын банкны нэгтгэлийн ахлагч - Х.Билгүүн
4. Даатгалын нэгтгэлийн ахлагч - Н.Эрдэнэтулга
5. Санхүү хариуцсан захирал - Г.Билгүүн
6. Компанийн нарийн бичгийн дарга, Тэргүүн Банкирар - А.Азбаяр
7. Аудит хариуцсан захирал - М.Мөнх-Эрдэнэ
8. Комплайнс хариуцсан захирал - Ө.Ашхүү

ТУЗ-ийн дарга санал хураалтын “Саналын хуудас”-ыг танилцууллаа.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 7: ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай

ТУЗ-ийн төсөвт гишүүдийн цалин, урамшуулал болон томилолтын зардлыг багтаан 2026 оны төсвийг 426 сая төгрөгөөр төлөвлөсөн. Энэ нь өмнөх жилийн түвшинтэй адил бөгөөд 2025 оны гүйцэтгэл нийт 95% байсан.

ТУЗ-ийн дарга санал хураалтын “Саналын хуудас”-ыг танилцууллаа.

Өөр санал хүсэлт байхгүй гэснээр санал хураалтын ажиллагаанд орлоо. Санал хураалтын дүн гарч байх хугацаанд ТУЗ-ийн дарга асуулт, хариулт явуулав.

1. Асуулт - Хувьцааны үнэ яагаад өсөхгүй байгаа болон ногдол ашиг яагаад тараахгүй байгаа талаар тодрууллаа.

Хариулт - Сүүлийн хоёр жилийн хугацаанд компанийг хоёр тусдаа бүтэц болгон салгаж, шинэ компаниудад стратегийн хөрөнгө оруулалт хийж, шаардлагатай дэд бүтэц, үйл ажиллагааны суурийг бүрдүүлэхэд төвлөрсөн. Иймд ашигт ажиллагааг богино хугацаанд бус, дунд болон урт хугацаанд нэмэгдүүлэх зорилгоор дахин хөрөнгө оруулалт хийж байгаа тул ногдол ашиг тараагаагүй бөгөөд зах зээл дээрх үнэ өсөлт удаашралтай байна.

Санал хураалтын дүнг нэгтгэж дууссан тул хурлыг үргэлжлүүлж, тооллогын комиссын зүгээс санал хураалтын дүн болон Тооллогын комиссын тогтоол, хурлаас гарсан тогтоолын хамт танилцуулахыг Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэлээс хүслээ.

Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл:

Хэлэлцэх асуудал-1: 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай

Санал хураалтын дүн

Нийт саналын эрхтэй хувьцаа	Зөвшөөрсөн		Татгалзсан		Түтгэлзсэн	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
12,231,149	11,907,785	97.36%	-	-	275,855	2.2%

Хэлэлцэх асуудал-2: Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай

Санал хураалтын дүн

Нийт саналын эрхтэй хувьцаа	Зөвшөөрсөн		Татгалзсан		Түтгэлзсэн	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
12,231,149	12,161,050	99.43%	-	-	-	-

Хэлэлцэх асуудал-3: ТУЗ-ийн 2026 оны зардлын төсвийг батлах тухай

Санал хураалтын дүн

Нийт саналын эрхтэй хувьцаа	Зөвшөөрсөн		Татгалзсан		Түтгэлзсэн	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
12,231,149	12,138,210	99.24%	-	-	22,590	0.1%

Хурлаас гарсан Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолуудыг уншиж танилцуулав. Үүнд:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны төсвийг батлах тухай
3. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах тухай

Хурал 14:22 минутад өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ